

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/174/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Ариунтуяа Утас:70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.25 № 2/97

танай _____ -ны № _____ -т

БУЛГАН СУМЫН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ
Б.ТҮМЭНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам" -ын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно", хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 63/104 дүгээр тушаалын хавсралтын 2 дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Аудитаар тендерт шалгараагүй аж ахуйн нэгжээс эм, эмнэлгийн 52,300.1 мянган төгрөгийн хэрэгсэл шууд худалдан авсан;
- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлт тооцоогүй 30,349.4 мянган төгрөгийг олгосон;
- Насжилт өндөртэй 44,484.3 мянган төгрөгийн авлага, өглөгийг барагдуулаагүй;

- Тендерийн эм тээвэрлэх зардалд 10,833.0 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг нийт 138,3 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ;

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 33628 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 697.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 3,404.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 280.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна.

Тайлант онд урсгал зардлаас 49,1 сая төгрөгийн, сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 228,4 сая төгрөгийн, төсөл хөтөлбөрийн хандив тусламжаар 306,0 сая төгрөгийн нийт 583,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 20,3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 зорилго 1 хөтөлбөр, 2 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 100 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд аймгийн Эрүүл мэндийн даатгалын газраас 97.4 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>710,514,750.25</u>	<u>1,184,462,463.74</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,557,479.39	2,202,373.74
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,557,479.39	2,202,373.74
3121	Төгрөг	3,557,479.39	2,202,373.74
31211	Төрийн сангийн харилцах	3,557,479.39	2,202,373.74
33	АВЛАГА	286,883,675.54	707,593,753.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,948,780.04	4,937,424.62
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.50	0.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага	277,094,800.00	697,814,529.90
335	Бусад авлага	4,840,095.00	4,841,798.13
3351	Байгууллагаас авах авлага	877,900.00	879,603.13
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,962,195.00	3,962,195.00
35	БАРАА МАТЕРИАЛ	420,005,595.32	474,598,336.85
351	Түүхий эд материал	255,134,433.48	307,503,715.01
35110	Тусгай зориулалттай материал	33,435,888.00	34,017,611.50
35130	Эм боох материал	221,698,545.48	273,486,103.51
354	Хангамжийн материал	162,831,161.84	165,054,621.84
35410	Бичиг хэргийн материал	931,000.00	1,091,000.00
35420	Аж ахуйн материал	14,460,700.00	14,460,700.00
35440	Түлш, шатах тослох материал	121,752,458.20	120,024,458.20
35460	Хүнсний материал	16,132,240.00	16,132,240.00
35470	Бусад хангамжийн материал	9,554,723.64	13,346,223.64
35600	Мал амьтад	2,040,000.00	2,040,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	68,000.00	68,000.00
36400	Шатахууны нөөц	68,000.00	68,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,388,657,163.73</u>	<u>7,610,852,708.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,388,657,163.73	7,610,852,708.81
392	Биет хөрөнгө	7,375,153,163.73	7,597,348,708.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,236,933,339.00	7,236,933,339.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(876,023,953.00)	(1,050,890,689.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	284,837,494.50	335,837,494.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(143,209,381.37)	(168,516,371.45)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,647,512,207.05	2,165,690,979.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(808,342,969.86)	(965,179,735.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,898,360.00	75,281,360.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,451,932.55)	(47,807,668.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,000,000.04)	(4,000,000.08)
393	Биет бус хөрөнгө	13,504,000.00	13,504,000.00
39301	Програм хангамж	1,525,000.00	1,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,525,000.00)	(1,525,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,504,000.00	13,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,099,171,913.98</u>	<u>8,795,315,172.55</u>

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>131,462,394.16</u>	<u>34,135,089.86</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	131,462,394.16	34,135,089.86
413	Өглөг	131,462,394.16	34,135,089.86
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	40,925,081.64	27,353,405.26
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	78,234,097.76	4,657,969.84
4136	Бусад өглөг	12,303,214.76	2,123,714.76
41361	Байгууллагад төлөх өглөг	11,733,680.76	1,554,180.76
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	569,534.00	569,534.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,967,709,519.82</u>	<u>8,761,180,082.69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,967,709,519.82	8,761,180,082.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,965,819.00	470,965,819.00
51101	Өмч: - төрийн	470,965,819.00	470,965,819.00
512	Хуримтлагдсан үр дүн	7,318,048,902.45	8,111,519,465.32
51210	Өмнөх үеийн үр дүн	7,318,048,902.45	7,318,048,902.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	793,470,562.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,694,798.37	178,694,798.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,099,171,913.98</u>	<u>8,795,315,172.55</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,712,527,310.00</u>	<u>4,740,159,509.46</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>27,883,750.00</u>	<u>634,736,527.46</u>
120	Нийтлэг татварын бус орлого	27,883,750.00	634,736,527.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,883,750.00	634,736,527.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,883,750.00	60,095,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		574,641,227.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,684,643,560.00</u>	<u>4,105,422,982.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	280,257,600.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	280,257,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,160,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,160,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,578,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,578,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,652,905,560.00	3,825,165,382.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,652,905,560.00	3,825,165,382.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>2,673,825,074.57</u>	<u>3,946,688,946.59</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,673,825,074.57</u>	<u>3,946,688,946.59</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,673,585,074.57	3,939,409,346.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,446,662,022.10	2,262,877,498.53
210101	Үндсэн цалин	870,505,384.86	1,087,131,813.94
210102	Нэмэгдэл	405,156,569.78	865,652,332.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,968,000.00	86,450,000.00
210104	Урамшуулал	151,073,727.46	200,378,451.15
210105	Гэрээт ажлын хөлс	3,958,340.00	23,264,900.46

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,966,425.22	290,424,904.23
210201	Тэтгэврийн даатгал	119,230,099.77	192,552,404.23
210202	Тэтгэмжийн даатгал	16,292,465.13	24,468,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,774,258.68	12,234,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,570,897.26	12,234,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,098,704.38	48,936,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,229,257.04	274,706,000.00
210301	Гэрэл, цахилгаан	24,436,939.04	25,984,539.96
210302	Түлш, халаалт	142,580,720.00	236,504,820.04
210303	Цэвэр, бохир ус	4,211,598.00	12,216,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	145,521,824.91	59,017,575.00
210401	Бичиг хэрэг	19,900,190.00	12,007,700.00
210402	Тээвэр, шатахуун	55,737,250.00	71,725,909.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,866,740.54	7,108,675.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,520,000.00	22,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,957,994.37	32,809,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	31,539,650.00	-
2105	Норматив зардал	477,997,864.71	580,657,917.21
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	424,828,124.71	525,750,017.21
210502	Хоол, хүнс	50,940,740.00	51,117,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,229,000.00	3,790,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,622,000.00	13,624,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,822,000.00	7,269,640.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	80,000.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	6,275,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,324,000.00	4,801,400.00
210702	Дотоод албан томилолт	3,324,000.00	4,801,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,411,550.00	16,122,910.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,054,600.00	5,541,750.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,503,950.00	1,227,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	202,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,375,600.00	3,997,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,477,400.00	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,850,130.59	372,520,592.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,450,000.00	11,154,365.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	226,400,130.59	361,366,227.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,000.00	7,279,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	7,279,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,279,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38,702,235.43	793,470,562.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,702,235.43	793,470,562.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,433,523,810.00	3,744,798,552.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,975,050.00	60,095,300.00

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	25,975,050.00	60,095,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,975,050.00	60,095,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,975,050.00	60,095,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,407,548,760.00	3,684,703,252.10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	280,257,600.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	280,257,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,160,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,160,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,578,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,578,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,375,810,760.00	3,404,445,652.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,375,810,760.00	3,404,445,652.10
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,432,920,454.41	3,696,894,157.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,432,920,454.41	3,696,894,157.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,432,680,454.41	3,689,614,557.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,428,020,377.00	2,258,715,526.85
210101	Үндсэн цалин	792,403,140.34	1,097,780,783.68
210102	Нэмэгдэл	471,012,841.76	865,652,332.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,947,000.00	86,450,000.00
210104	Урамшуулал	148,657,394.90	185,294,864.15
210105	Гэрээт ажлын хөлс	-	23,537,546.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,265,153.83	308,148,900.00
210201	Тэтгэврийн даатгал	118,091,800.00	210,276,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,375,071.31	24,468,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,114,500.00	12,234,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,897,482.52	12,234,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,786,300.00	48,936,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,737,837.04	272,978,000.00
210301	Гэрэл, цахилгаан	24,436,939.04	25,984,539.96
210302	Түлш, халаалт	126,089,300.00	234,776,820.04
210303	Цэвэр, бохир ус	4,211,598.00	12,216,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	93,068,040.00	100,900,984.00
210401	Бичиг хэрэг	11,507,140.00	11,600,400.00
210402	Тээвэр, шатахуун	67,683,500.00	62,296,209.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,285,000.00	7,108,675.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,837,000.00	22,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,755,400.00	19,873,700.00
2105	Нормативт зардал	494,228,406.00	673,699,388.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	438,437,366.00	618,392,671.90
210502	Хоол, хүнс	47,124,340.00	47,828,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,666,700.00	7,478,666.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,697,700.00	35,788,898.90

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	16,688,700.00	23,828,898.90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	80,000.00
210604	Урсгал засвар	5,009,000.00	11,880,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,324,000.00	4,801,400.00
210702	Дотоод албан томилолт	3,324,000.00	4,801,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,799,630.54	19,581,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,147,639.08	9,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	903,950.00	1,227,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	202,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,019,600.00	3,997,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,728,441.46	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,539,310.00	15,000,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,539,310.00	15,000,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	240,000.00	7,279,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	240,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	7,279,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,279,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	603,355.59	47,904,394.35
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	49,259,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	49,259,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	49,259,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	49,259,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(49,259,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	603,355.59	(1,355,105.65)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,557,479.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,557,479.39	2,202,373.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,965,819.00	178,694,798.37	7,318,048,902.45	7,967,709,519.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	27,732,910.34	27,732,910.34

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	937,525,862.02	937,525,862.02
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-		
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	470,965,819.00	178,694,798.37	7,318,048,902.45	7,967,709,519.82
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	793,470,562.87	793,470,562.87
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,111,519,465.32	8,761,180,082.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,239,115,600.00	3,738,874,057.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,239,115,600.00	3,738,874,057.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,239,115,600.00	3,738,874,057.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,580,691,400.00	2,258,715,526.85
210101	Үндсэн цалин	1,174,327,000.00	1,097,780,783.68
210102	Нэмэгдэл	1,083,458,600.00	865,652,332.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	103,922,000.00	86,450,000.00
210104	Урамшуулал	218,983,800.00	185,294,864.15
210105	Гэрээт ажлын хөлс	-	23,537,546.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	319,148,900.00	308,148,900.00
210201	Тэтгэврийн даатгал	221,276,400.00	210,276,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,468,100.00	24,468,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,234,100.00	12,234,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,234,100.00	12,234,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,936,200.00	48,936,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,257,600.00	272,978,000.00
210301	Гэрэл, цахилгаан	24,795,000.00	25,984,539.96
210302	Түлш, халаалт	237,723,400.00	234,776,820.04
210303	Цэвэр, бохир ус	12,739,200.00	12,216,640.00
2104	Хангамж, бараа материалын зардал	131,478,000.00	107,900,984.00
210401	Бичиг хэрэг	13,690,500.00	11,600,400.00
210402	Тээвэр, шатахуун	65,300,000.00	62,296,209.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,249,100.00	7,108,675.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,571,500.00	22,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,666,900.00	26,873,700.00
2105	Нормативт зардал	754,651,300.00	673,666,388.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	688,617,200.00	611,752,471.90

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210502	Хоол, хүнс	57,435,300.00	54,435,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,598,800.00	7,478,666.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,646,700.00	78,048,398.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,527,900.00	66,088,398.90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,333,200.00	80,000.00
210604	Урсгал засвар	25,785,600.00	11,880,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,708,600.00	4,801,400.00
210702	Дотоод албан томилолт	8,708,600.00	4,801,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,532,800.00	19,614,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,000,000.00	9,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,247,400.00	1,227,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800.00	202,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,425,600.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,978,000.00	3,997,000.00
210807	Газрын төлбөр	120,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,500,000.00	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,300.00	15,000,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,300.00	15,000,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,239,115,600.00	3,737,518,952.10
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	280,257,600.00	272,978,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	280,257,600.00	272,978,000.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,924,467,700.00	3,404,445,652.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,924,467,700.00	3,404,445,652.10
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	34,390,300.00	60,095,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,390,300.00	60,095,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,557,479.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,202,373.74
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	89.00	89.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	61.00	61.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 138,296.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулаагүй алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Шилэн дансны цахим сайтад мэдээлэх 67 мэдээллийг аудитын явцад залруулан 3,738,874.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг нөхөн мэдээлсэн
Залруулагдаагүй нийт 138,296.9 мянган төгрөгийн 5 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 138,296.9 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 330.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 137,966.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Томилолтоор ажилласан ажилтанд унаа хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Ур чадварын нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ур чадварын нэмэгдэл олгоходоо шалгуур үзүүлэлт тооцоогүй олгосон нь "Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам" -ын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно", хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 63/104 дүгээр тушаалын хавсралтын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-р хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмыг баримтлан тушаал шийдвэрээр олгох. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 09-ны 238 дугаар тогтоолыг баримтлан ажиллах.

3.2.2 Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Он дамжсан, насжилт өндөртэй авлага, өглөгийг барагдуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан насжилт өндөртэй авлага, өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулан барагдуулах

3.2.3 ЭМИЙН ХУДАЛДАН АВАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас Ховд аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн 2024 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуур нийлүүлэх тендер зарлаж, нийлүүлэх аж ахуйн нэгжүүд болон эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах нэг бүрийн үнийг тогтоож өгсөн байхад тендерт ороогүй аж ахуй нэгж байгууллагаас эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалын хавсралт " бараа худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг ", 36 дугаар зүйл гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах "Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Бараа" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерийн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, төсвийн хөрөнгийг үр өгөөжийг дээшлүүлэх.

3.2.4 Тендерийн эм тээвэрлэх зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тендерийн эм тээвэрлэх зардалд 10,833.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд аудит хянахад тендерийн гэрээний заалтад нэмэлт оруулж зохицуулах боломжийг ашиглаагүй нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерийн гэрээний заалтад нэмэлтээр оруулж зохицуулалт хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Булган сумын Нэгдсэн эмнэлэг	Шилэн дансны 67 мэдээллийг нөхөн тайлагнасан	1	3,738,874.0	1	3,738,874.0			1	3,738,874.0				
Нийт дүн		1	3,738,874.0	1	3,738,874.0			1	3,738,874.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Булган сумын Нэгдсэн эмнэлэг	Томилолтоор ажилласан ажилтанд хоолны мөнгө давхцуулан олгосон	1	330.0	1	330.0							
	Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлт тооцоогүй олгосон	1	30,349.4					1	30,349.40			
	Насжилт өндөртэй авлага, өглөгийг барагдуулаагүй	1	44,484.3					1	44,484.30			
	Эмийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн	1	52,300.1					1	52,300.10			

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тендерийн эм тээвэрлэх зардалд 10,833.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд аудит хянахад тендерийн гэрээний заалтад нэмэлт оруулж зохицуулах боломжийг ашиглаагүй	1	10,833.0					1	10,833.00		
Нийт дүн	5	138,296.80	1	330.0	0	-	4	137,966.8	0	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		